



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/82

Бүрэн сум

Тариалангийн штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. дэх хэсэг, Тариалангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн “Тариалангийн штаб байгуулах тухай” А/248 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны газар тариалангийн чиглэлээр сумын Засаг даргаас аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний гүйцэтгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Пүрэв-Очир

(Засаг даргын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Ц.Лхагва

(Төхөм 1-р багийн Засаг дарга)

З.Пүрэв-Очир

(Баянцогт 2-р багийн Засаг дарга)

Д.Батмөнх

(Монгол 3-р багийн Засаг дарга)

Д.Батмөнх

(Эрдэнэхангай 4-р багийн Засаг дарга)

Б.Оюун-Эрдэнэ

(Өнжүүл 5-р багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: П.Анхцэцэг


(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

2.Газар тариалан эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас тариалалтын мэдээг авч нэгтгэн 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн долоо хоног бүрийн Даваа, Пүрэв гарагуудад 12 цагаас өмнө Аймгийн штабт хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нар, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (П.Анхцэцэг) нарт тус тус даалгасугай.

3.Төмс хүнсний ногоо, жимс, жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (П.Анхцэцэг)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Отгонхишигт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТҮВШИНБАТ

412305188

1423040013 9059725 НД1359